

## **АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1. Ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдал**

Монгол Улсад хот, суурин газар бий болж ус хангамж, цэвэрлэх байгууламжийг хөгжүүлж эхэлснээр нийтийн аж ахуйн салбар бүрэлдэн тогтож, түүний үйл ажиллагаа нь хүмүүсийн ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, хүрээлэн байгаа орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулж ирсэн билээ.

Гэвч хүн ам өсөж төв, суурин газрын нягтрал ихсэн, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ өргөжөхийн хирээр цэвэрлэх байгууламж нь бохир усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж чадахгүй байгаа явдал нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Манай улсын нийт 2.5 сая хүн амын 1.4 сая орчим нь төв, суурин газарт амьдарч байгаагийн зөвхөн 22.0 хувь нь ариутгах татуургын сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байна. Хүн амын дийлэнх нь оршин суудаг гэр хороолол болон зуслан, суурин газрын эмнэлэг, сургууль, алслагдсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралт, сувиллын газар, жуулчны баазад бохир ус татан зайлуулах систем байхгүйгээс нүхэн жорлонг ашиглаж хөрс, ус болон байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна.

Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, тоног төхөөрөмжийн байдалд хийсэн үзлэгийн дүнгээс үзэхэд улсын хэмжээнд нийт 103 цэвэрлэх байгууламж байгаагаас цэвэрлэгээний түвшин нь стандартын шаардлагын хэмжээнд хүрсэн хэвийн ажиллагаатай 41 (39.8 хувь), хэвийн бус ажиллагаатай 27 (26.2 хувь), ажиллагаагүй 35 (34.0 хувь) байгууламж тус тус байна.

Хөрөнгө санхүүгийн хомсдлоос шалтгаалан цэвэрлэх байгууламжид цаг тухайд нь засвар үйлчилгээ, техник, технологийн шинэчлэлт хийгдээгүй, аймгийн төв, суурин газрын үйлдвэр, аж ахуйн байгууллагын үйлдвэрлэл багассаны улмаас цэвэрлэх байгууламжид цугларах бохир усны хэмжээ эрс багасч, технологийн горим алдагдан цэвэрлэгээний түвшин буурч, улмаар бохир усыг голд шууд хаяж байна. Мөн орон нутагт цэвэрлэх байгууламжийг хариуцан ажиллуулах мэргэжлийн байгууллага, хүнгүй болж, тэдгээрийн үйл ажиллагаа бүрэн зогссон байна.

Цэвэрлэгээний түвшинг лабораторийн шинжилгээгээр тогтоосны үндсэнд технологийн горим мөрдүүлэх шаардлагатай байдаг боловч, өнөөдрийн байдлаар Улаанбаатар, Багануур, Дархан-Уул, Орхон, Зүүнхараа, Хөтөлийн цэвэрлэх байгууламжаас бусдад нь цэвэрлэгээний түвшинд хяналт тавих лаборатори байхгүй байна.

Цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэрлэсэн усанд умбуур бодис, аммиак, нитрит, хром, нефтийн

бүтээгдэхүүн, өөх тос зэрэг бодисууд зөвшөөрөгдөх хэмжээнээс их байх тохиолдол байнга гарч байна.

Мөн арьс ширний үйлдвэрээс гарч байгаа бохир усанд хийсэн шинжилгээний дүнгээс харахад төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх химийн хэрэгцээт хүчилтөрөгч, умбуур бодисын хэмжээ нь зөвшөөрөгдөх агууламжаас 5-20 дахин их байгаа бөгөөд сульфат, сульфитын агууламж бүхий бохир ус нийлүүлэгдсэнээр Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн технологийн горимд доголдол үүсэх үндсэн нөхцөл болж байна.

Дээрхи байдал цаашид үргэлжилбэл Туул, Хараа, Хангал, Ерөө, Орхон голууд бохирдож, экологийн цэвэр тунгалаг шинжээ алдахад хүрэх юм. Иймд байгаль орчныг бохирдлоос хамгаалах, хүн амын тав тухтай амьдрах орчинг бий болгоход ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

## 1.2. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, өвчин, эмгэгт хүргэж байгаа, ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нэг үндэслэл болж байна.

Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт”-д 2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг 2 дахин бууруулах, 1990 оны суурь дундажтай харьцуулахад баталгаат эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувийг 70 хувьд, эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг 50.0 хувь болгон өсгөх зорилтыг тус тус дэвшүүлж тавьсан байна.

Мөн 2002 онд болсон Тогтвортой Хөгжлийн Дэлхийн Чуулга уулзалтаас гаргасан Йоханнесбургийн Үйл ажиллагааны төлөвлөгөөнд ус хангамж, ариун цэврийн шаардлага хангаагүй байгууламжтай хүн амын тоог 2 дахин бууруулах нь хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх нэг гол арга зам гэж тодорхойлсон байдаг.

Иймд ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөрийг дэлхий нийтийн чиг хандлага, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсрууллаа.

1.3 Энэ хөтөлбөрт хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “ариун цэврийн байгууламж” гэж нийтийн бохирын шугам, цооног, агааржуулагчтай болон энгийн нүхэн жорлон, цэвэрлэх байгууламжийг;

1.3.2. “урьдчилсан цэвэрлэх байгууламж” гэж бохир усыг төвийн шугамд шууд хаяж болохгүй үүднээс урьдчилсан цэвэрлэгээ хийх зориулалттай байгууламж, тоног төхөөрөмжийг;

1.3.3. “бохирдуулагч” гэж цэвэр усыг аж ахуйн үйл ажиллагаанд ашиглаж бохирдуулсан хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

## **ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНДСЭН ЗАРЧИМ**

2.1. Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөрийн эрхэм зорилго нь цэвэрлэх байгууламжийн технологи, ашиглалт үйлчилгээг сайжруулах, хувийн орон сууц, гэр хорооллыг цэвэр, бохир усны системд холбон хүн амын ая тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх таатай нөхцлийг хангах, алслагдсан газарт нүхэн жорлонгийн сайжруулсан хувилбарыг ашиглах нь байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, хүн амын эрүүл ахуйн нөхцлийг сайжруулж, нийгэм эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмыг баримтална:

2.2.1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Усны үндэсний хөтөлбөр болон бусад хөтөлбөрийн зорилттой уялдуулан хэрэгжүүлэх;

2.2.2. салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, холбогдох норм стандартыг шинэчлэн мөрдүүлэх;

2.2.3. ариун цэврийн байгууламжийн өнөөгийн түвшинг дээшлүүлэхэд дэвшилтэт шинэ техник технологи нэвтрүүлж, цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинг сайжруулах, гэр хорооллыг бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох, алслагдсан газарт нүхэн жорлонгийн сайжруулсан хувилбарыг нэвтрүүлэх, үйлдвэрийн урьдчилсан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулах;

2.2.4. мэргэжлийн боловсон хүчнийг сургаж дадлагажуулах;

2.2.5. ариун цэврийн байгууламжийг сайжруулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

2.2.6. ариун цэврийн байгууламжийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагааг уялдуулан нөөцийг оновчтой хувиарлаж, хандивлагч, олон улсын байгууллагын туслалцаа, дэмжлэг, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.2.7. хяналтын тогтолцоог боловсронгуй болгох.

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ**

3.1. Хөтөлбөрийг 2015 он хүртэл хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааг дараахь үе шатаар төлөвлөнө:

3.1.1. нэгдүгээр үе шат - 2006-2010 он. Энэ хугацаанд ариун цэврийн байгууламжийн хууль эрх зүйн орчинг шинэчлэх, удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгох, хяналтын тогтолцоог бий болгох, ариун цэврийн байгууламжид

шинэ техник, технологи нэвтрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.2. хоёрдугаар үе шат - 2010-2015 он. Энэ хугацаанд хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны хэрэгжилтийн байдлыг үндэслэн ариун цэврийн байгууламжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэн өргөжүүлэх.

3.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.2.1 улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

3.2.2. хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, хандив;

3.2.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

3.2.4. төрийн болон төрийн бус байгууллагын санаачилгаар хуримтлагдсан хөрөнгө;

3.2.4. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

3.2.5. бусад эх үүсвэр.

### **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ҮР ДҮН**

4.1. **Зорилт 1:** Ариун цэврийн байгууламжийн хууль, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, хяналт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгоно.

4.2. Үйл ажиллагааны чиглэл:

4.2.1. ариун цэврийн байгууламжийн талаарх хууль тогтоомж, стандартыг шинэчлэх, боловсронгуй болгох /Бохирдуулагч нь төлөх зарчимд үндэслэсэн Бохир усны төлбөрийн тухай хуулийг боловсруулж, мөрдүүлэх/;

4.2.2. ариун цэврийн байгууламжийг сайжруулах үйл ажиллагаанд хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих асуудлыг судалж хэрэгжүүлэх;

4.2.3. ариун цэврийн байгууламжын үйл ажиллагааг хянах тогтолцоог бий болгох (лабораториор хангах, орон нутагт хяналтын байцаагчтай болох);

4.2.4. ариун цэврийн байгууламжын үйл ажиллагааг сайжруулах, бохир усны цэвэрлэгээний түвшинг дээшлүүлэх чиглэлээр шинэ техник, технологи нэвтрүүлэх боломжийг судалж нэвтрүүлэх;

4.2.5. аймаг, орон нутагт ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжын үйл ажиллагааг хариуцан ажиллах аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

4.3. Хүрэх үр дүн:

4.3.1. ариун цэврийн байгууламжийг сайжруулах эрх зүйн орчин бүрдэнэ. Бохирдуулагчаас гарч байгаа бохир усны зэрэглэлээр бохирдуулагч нь бохир усны

төлбөр төлөх зарчим хэрэгжиж, ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагааг дээшлүүлэх эдийн засгийн таатай нөхцөл бий болно;

4.3.2. дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг энэ салбарт түлхүү татан оролцуулах таатай нөхцөл бүрдэнэ;

4.3.3. хувийн орон сууц, гэр хорооллын бохир усыг татан зайлуулах шугам сүлжээг хувийн хэвшлийн хөрөнгөөр барьж байгуулах замаар салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;

4.3.4. бохир ус цэвэрлэгээний түвшин дээшилснээр байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл багасч, усны нөөцийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ;

4.3.5. ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа сайжирснаар хүн амын халдварт өвчлөл багасч, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд амьдрах боломжтой болно.

4.4. **Зорилт 2:** Ариун цэврийн байгууламжид дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг сайжруулан хэвийн найдвартай ажиллагааг хангана.

4.5.1. төв, суурин газрын ариутгах татуургын нэгдсэн сүлжээг өргөтгөн тэлэх;

4.5.2. одоо ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжийн тоног, төхөөрөмжийг сэргээн засварлаж, шинэчлэх, техник, технологийг сайжруулах;

4.5.3. бага оврын цэвэрлэх байгууламжийн технологиор суурин газрын ариутгах татуургийг холбох замаар бохир усыг зайлуулан ариун цэврийг сайжруулах асуудлыг шийдэх;

4.5.4. байрын цэвэрлэх байгууламжийн техник технологи нэвтрүүлэх:

- хорт бодис ихээр гаргадаг үйлдвэр, аж ахуйн газрыг бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох;

- төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй эмнэлэг, сургууль, зуслан, амралт сувиллын болон, аялал жуулчлалын газар, гэр хороолол, хувийн орон сууцанд агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон, хуурай жорлон, ашиглалтын болон суурилуулалтын өртөг зардал багатай бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах.

4.5.5. бохир усны цэвэрлэгээнээс гарсан лагийг боловсруулах технологи нэвтрүүлэх;

4.5.6. цэвэрлэгдсэн бохир усыг /саарал усыг/ эргүүлэн ашиглах технологи судалж нэвтрүүлэх.

4.6. Хүрэх үр дүн:

4.6.1. ариун цэврийн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийн эзлэх хувийг 2015 онд 50 хувьд хүргэх талаар дэвшүүлсэн Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт биелэгдэнэ;

4.6.2. 2015 он гэхэд нийт хүн амын 36.6 хувь нь төвлөрсөн ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоно.

4.6.3. цэвэрлэгээний түвшин нь стандартын шаардлагын хэмжээнд хүрсэн цэвэрлэх байгууламжийн тоог 71-д хүргэх;

4.6.4. эрчим хүчний хэмнэлттэй, цэвэрлэгээний түвшин өндөр, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, бага оврын цэвэрлэх байгууламжийн технологийг нэвтрүүлэх

4.6.5. Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрүүд урьдчилан цэвэрлэх байгууламжтай болсоноор төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг багасгаж, цэвэрлэгээний түвшин өндөрсөнө.

4.6.6. төв, суурин газрын оршин суугчдын ажиллаж амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх таатай орчин бүрдэж, хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.

4.7. **Зорилт 3:** Салбарын хүний нөөцийг бэхжүүлэн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.

4.8. Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

4.8.1. салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох.

4.8.2. Хүн амын дунд явуулах ариун цэврийн байгууламжийн талаархи мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах, албан ба албан бус сургалт явуулах.

4.8.3. Хүн малын ялгадас, бохир уснаас үүдэлтэй байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй сөрөг нөлөөлөл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа явуулах

4.9. Хүрэх үр дүн:

4.9.1. Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхи нэмэгдэнэ.

4.9.2. Ариун цэврийн байгууламжийн талаархи мэдлэгийн түвшин дээшилж эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломж бүрдэнэ.

## **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

5.1. Удирдлага, зохион байгуулалт:

5.1.1. нийтийн аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийг эдийн засаг, нийгмийн бусад холбогдох хөтөлбөртэй уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийтийн аж ахуйн байгууллагууд хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

5.2. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

5.2.1. хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, анхаарах асуудлыг нэгтгэн дүгнэх, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг холбогдох байгууллагад тайлагнах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ;

5.2.2. хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг нийтийн аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ;

5.2.3. хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хөтөлбөрийн зорилт тус бүрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтээр гаргана.

5.3. Хөтөлбөрийн үр дүнг дараах үзүүлэлтээр гаргана:

5.3.1. ариун цэврийн шаардлага хангах нөхцөлд амьдарч байгаа хүмүүсийн эзлэх хувь 2015 онд 50.0 хувьд хүрсэн байх;

5.3.2. цэвэрлэгээний түвшин нь стандартын шаардлагад хүрсэн цэвэрлэх байгууламжийн тоо 71-д хүрсэн байх;

5.3.3. сайжруулсан ариун цэврийн байгууламжийг ашиглах бодлого боловсруулах, зохицуулах, зах зээлийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах чадвартай, өндөр мэргэжлийн боловсон хүчин системтэй бэлтгэгддэг болох;

5.3.4. ариун цэврийн байгууламжийг ашиглах үйл ажиллагаанд нийтийн аж ахуйн үйлчилгээ эрхэлдэг компани, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага түлхүү оролцох боломжтой болох;

5.3.5. бохирдуулагч нь төлбөр төлөх зарчим нэвтэрч, хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизм нэвтрэх;

5.3.6. гэр хорооллын 8-10 хувь нь бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох.